

## **Томууны эсрэг вакцинжуулалт**

### **Жирэмсэн эмэгтэй танд чиглэсэн мэдээлэл**

Жирэмсэн эмэгтэй та томуу туссанаар хүндээр өвчлөх эрсдэл илүү өндөртэй байдаг. Иймд та жирэмслэлтийн 16 долоо хоногтойгоос хойш томууны эсрэг вакциныг хийлгэвэл зохистой. Вакцинжуулалт нь жирэмслэлт болон ургийн хөгжилд нөлөөлөхгүй.

### **Томуу жирэмсэн эмэгтэйчүүдэд илүү аюултай**

Жирэмсэн үедээ томуу туссан ихэнх эмэгтэйчүүд төдийлөн өвчилдөггүй боловч тэдэнд хүндээр өвчлөх эсвэл амь насаа алдах эрсдэл бусад эрүүл хүмүүсээс илүүтэй байдаг.

### **Жирэмсэн эмэгтэйчүүд вакцинжуулалтад хамрагдах нь зүйтэй**

Иргэдийн эрүүл мэндийн алба жирэмсэн эмэгтэйчүүдэд 11- 4 дүгээр сарын хооронд томууны эсрэг вакцин хийлгэхийг зөвлөж байна. Вакциныг жирэмслэлтийн 16 долоо хоногтойгоос хойш хийлгэхийг зөвлөж байна, учир нь томуугаар хүнд өвдөх эрсдэл жирэмсэний сүүл үед хамгийн өндөр болно.

Хэрэв танд томуугаар хүнд өвчлөх эрсдэл өндөр бүхий өөр хүчин зүйлүүд бий бол уг вакциныг илүү эрт хийлгэх нь зүйтэй. Ийм хүчин зүйлүүдэд зүрхний архаг өвчин, уушигны архаг өвчин, чихрийн шижин болон хэт таргалалт орж болно. Вакциныг жирэмсэний бүхий л хугацаанд хийлгэхэд найдвартай.

### **Вакцинжуулалт нь урагт нөлөөлөхгүй**

Вакцинжуулалт нь урагт нөлөөлөхгүй. Шинжлэх ухааны олон судалгаанаас үзэхэд жирэмсэн үед вакцин хийлгэсэн ургийн хөгжил вакцин хийлгээгүй ургийн хооронд ялгаа алга байна.

### **Вакцин нь нярайг бас хамгаална**

Та вакцин хийлгэсэн бол бас нярай хүүхэд тань төрсөний дараах эхний саруудад томуунаас тодорхой хэмжээнд хамгаалагдах болно. Энэ нь танд байгаа эсрэг биетүүд жирэмсэн үед урагт шилжин очдогт оршино. Үүнээс гадна таны томуугаар өвдөж хүүхэддээ халдварлах эрсдэл багасна.

### **Гаж нөлөөнүүд нь хөнгөвтөр**

Томууны вакцин гаж нөлөөнүүд үзүүлж болно. Гэвч вакцины ашиг тус нь эрсдэлээсээ илүүтэй. Хамгийн нийтлэг гаж нөлөөнүүд хөнгөн хэлбэрээр илэрдэг ба хурдан арилдаг ( дараагийн мөрнөөс хар).

Уг вакцин томуугаар өвчлүүлэхгүй. Улирлын чанартай томууны вакцин болон нарколепси (нойрсох өвчин) хоёр нь хоорондоо холбоогүй.

**НИЙТЛЭГ ГАЖ НӨЛӨӨНҮҮД** (вакцин хийлгэсэн 100 хүнээс наанадаж нэг хүнд): тарилга хийлгэсэн хэсэгт хөндүүрлэх, улайх, хавдах, халуурах, бие зарайх, толгой өвдөх, хөлрөх, булчин эсвэл үе мөч өвдөх

**НИЙТЛЭГ БУС ХОВОР ГАЖ НӨЛӨӨНҮҮД:** харшлын шинж тэмдэгүүд, загатнуур, тууралт, мэдрэлийн өвчин

#### **Бүх хүмүүст вакцин таарахгүй**

Уг вакцинд өндөгний уураг бага хэмжээгээр байж болох ба энэ нь ихэнх томууны вакциныг тахианы өндөгт томууны вирус үржүүлж гаргаж авдагтай холбоотой. Та өндөгний хурц хэлбэрийн харшилтай бол эмчид хандаарай. Вакцинд агуулагддаг бусад зүйлээс харшилтайгаа мэддэг эсвэл урьд өмнө вакцинаас харшил авч байсан бол мэдэгдэж хэлэх хэрэгтэй.

#### **Вакцин нэг улирал үйлчилдэг**

Томууны вакцины үйлчилгээ 6-9 сар буюу томууны нэг улиралд хүчинтэй байдаг. Уг вакцин гурван төрлийн томуунаас хамгаалдаг. Эдгээр төрлүүд хэсэг хугацааны дараа өөрчлөгдөн заримдаа шинэ төрлийн вирус бий болно. Иймд шинэ улирал тутам вакциныг сольдог.

#### **Томуу туссан жирэмсэн эхчүүд эрүүл мэндийн байгууллагат хандах Хэрэгтэй**

Жирэмсэн эмэгтэйчүүд томуу туссанаар хүндээр өвчилж болохыг мэдэж байх нь чухал, энэ нь ялангуяа жирэмсэний сүүлийн саруудад хамааралтай. Та өөрийгөө томуу туссан гэж бодож байвал хүндээр өвчилөөгүй ч, жирэмсэний хэдэн долоо хоногтой ч хамаагүй шууд эмнэлэг эрүүл мэндийн байгуулагт хандаарай. Танд жишээ нь аль болох яаралтай уувал сайн үйлчилдэг вирусын эсрэг эм хэрэгтэй байж болох юм.

#### **Та илүү дэлгэрэнгүй мэдээлэл уншихыг хүсч байгаа бол**

Томууны эсрэг вакцины тухай мэдээлэлийг 1177 хэмээх эрүүл мэндийн зөвөлгөөний (vårdguiden) дугаар руу залгах

Томуу ба жирэмслэлтийн тухай мэдээлэлийг Infpreg цахим хуудаснаас авах  
Гаж нөлөөний тухай Эм бэлдмэлийн албаны (Läkemedelsverket) цахим хуудаснаас авах